

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.040.30

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй Ажлын байрны агаар дахь хар тугалгын агууламж, ажлын байранд тавигдах шаардлага	MNS 5803 : 2007
Occupational safety and health. General requirements for lead content in workplace air and the workplace.	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 11 дүгээр сарын 08 - ний өдрийн 46 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2007 оны 12 дугаар сарын 01 -ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1 Зорилго

Энэ стандартын зорилго нь хар тугалгын нөлөөлөл бүхий ажлын байрны агаар дахь хар тугалгын агууламжийг хянах, хар тугалгатай харьцан ажиллаж байгаа иргэн, ажилтанг хар тугалгын нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг нь хамгаалахад оршино.

2 Хамрах хүрээ

Энэ стандарт нь хар тугалгатай харьцан ажилладаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшлийн ажлын байрны агаар дахь хар тугалгын агууламжийг тогтоох, ажилтан, иргэнийг хар тугалгын ямар нэгэн нөлөөлөлд өртөж өвчлөхөөс хамгаалахад баримтлах ерөнхий шаардлага болно.

3 Нэр томъёо, тодорхойлолт

3.1

Үйлчлэлийн түвшин

Ажлын 8 цагийн үргэлжлэх явцад 1 шоо метр агаар дахь хар тугалгын дундаж хэмжээ 30 мкг/м³-ээс ихгүй байна

3.2

Нөлөөллийн зөвшөөрөх түвшин

Ажлын 8 цагийн үргэлжлэх явцад 1 шоо метр агаар дахь хар тугалгын дундаж хэмжээ 50 мкг/м³-ээс ихгүй байна.

4 Ажлын байрны агаар дахь хар тугалгын агууламжид тавигдах шаардлага

4.1 Ажлын байрны агаар дахь хар тугалгын агууламж 0,01мг/м³-ээс ихгүй байна.

4.2 Ажлын байрны агаар дахь хар тугалгын агууламжийг 6 сар тутамд хянана.

4.3 Ажилчид жилд **30-аас** дээш өдөр нөлөөллийн зөвшөөрөх түвшингээс их хар тугалга бүхий орчинд ажиллах тохиолдолд ажлын байрны агаар дахь хар тугалгын хэмжээг 3 сар тутамд хянаж тогтооно.

5 Ажлын байранд тавигдах шаардлага

5.1 Ажлын байр нь хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартын дагуу тоноглогдсон байна.

5.2 Ажлын байранд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Хоолны болон усанд орох, хувцас солих өрөө
- Ажлын байранд өдөр бүр нойтон цэвэрлэгээг хийсэн байх

5.3 Хар тугалгатай харьцаж ажиллаж байгаа иргэн, ажилтан улирал бүр 8-аас доошгүй цагийн сургалтанд хамрагдаж, шалгалт өгсөн байх

6. Эмнэлгийн үзлэг шинжилгээ, түүний давтамж

6.1 Жилд 30-аас дээш өдөр үйлчлэлийн түвшингээс их хар тугалга бүхий орчинд ажиллаж байгаа тохиолдолд 6 сар тутамд ажилтан, иргэнийг цусан дахь хар тугалгын агууламж, улаан цогцсын протопорфирины хэмжээг тодорхойлох шинжилгээнд оруулж байна.

6.2 Цусан дахь хар тугалгын агууламж 40 мкг/дл ба түүнээс дээш байвал 2 сар тутамд давтан шинжилгээнд оруулж байна.

6.3 Цусан дахь хар тугалгын агууламж сүүлийн 6 сард 50 мкг/дл ба түүнээс дээш илэрсэн бол хар тугалгатай харьцан ажиллахыг хориглож, ажилтан, иргэний хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх арга хэмжээ авч, сар бүр давтан шинжилгээнд оруулна.

6.4 Хар тугалгатай харьцаж ажиллагч ажилтан, иргэнийг дараах үзлэг шинжилгээнд хамруулна (1-р хүснэгт)

Эмнэлгийн байнгын үзлэгээр заавал хийх үзлэг ба шинжилгээ

1-р хүснэгт

1.	Үзлэг: <ul style="list-style-type: none">○ Цусны даралт○ Буйл, шүд○ Уушги○ Зүрх судас○ Ходоод гэдэс○ Бөөр○ Мэдрэл	Хугацаа: 12 сард 1 удаа
2.	Лабораторийн шинжилгээ: <ul style="list-style-type: none">○ Цусан дахь хар тугалгын хэмжээ○ Цусны ерөнхий шинжилгээ○ Цусан дахь цайрын протопорфирины хэмжээ○ Цусан дахь мочевин, креатининий хэмжээ○ Шээсний шинжилгээ○ Жирэмсний сорил (хэрэв ажилтан хүсвэл)○ Үрийн шинжилгээ (хэрэв ажилтан хүсвэл)	Хугацаа: 12 сард 1 удаа

ТӨГСӨВ